

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ УРЬЖ
БАЙНА**

2020.12.04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг баталсан. Дээрх тогтоолд Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор “8000 хүүхэд тутамд хүүхдийн байцаагч” байхаар нэмэлт орсонтой холбогдуулан алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдэд 2021 оноос хүүхдийн байцаагчийн албан тушаалын орон тоог нэмэхээр төсөвлөгдсөн.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д “төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас” гэж заасны дагуу хүүхдийн байцаагчийн сул орон тоог цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагчийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан бакалавр түүнээс дээш боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй алба хаагчдаас сонгон шалгаруулах ажлыг 2020 оны 12 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулах гэж байна.

Дээрх шаардлагыг хангасан ахлагчийн албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчид 2020 оны 12 дугаар сарын 07-ноос 21-ний өдрүүдэд hrm.police.gov.mn цахим хаягаар бүртгүүлнэ үү.

Алба хаагчдад тавигдах ерөнхий шаардлага:

- Эрх зүйн бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
- Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг сахиж, тогтвор суурьшилтай ажилласан байх
- Нөхцөл байдлыг зөв үнэлж, шийдвэр гаргах, багаар ажиллах, харилцааны ур чадвар эзэмшсэн байх, монгол хэл бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих чадвартай байх,

Жич: Багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэх чиглэлийн мэргэжилтэй болон 1 жилээс доошгүй хугацаагаар дээрх мэргэжлээр ажилласан бол давуу тал болно.

Тодруулах зүйлийг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн 70191041, 70191043 дугаарын утсаар холбогдож лавлана уу.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР